



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 06 өдөр

Дугаар А/06

Чингис хот

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1-ийн "а", Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гамшгаас хамгаалах Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин ажиллах хугацаанд Цэнхэрмандал сумын "Хэрлэн гүүр", "Дивизын гарам", Хэрлэнбаян-Улаан тосгоны "Аягын гарам", Бор-Өндөр сумын "Төмөрт Овоо", "Отволь", Хэрлэн сум "Жаст-Ойл" зэрэг 6 цэгт 2021 оны 01 дүгээр сарын 06-ны өдрөөс 2021 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийг хүртэл 10 хоногийн хугацаанд ажиллах 22 алба хаагчийн хоол, бичиг хэрэг, 6 автомашины шатах тослох материалын зардлыг нэгдүгээр, аймгийн "Шуурхай штаб"-т 24 цагаар үүрэг гүйцэтгэж, жижүүрт ажиллах алба хаагчдын бичиг хэрэг, хоол, шатахууны зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж ажиллахад шаардагдах 8136200 /найман сая нэг зуун гучин зургаан мянга хоёр зуун/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ц.Чогсомжав/-д даалгасугай.


ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

• 231010022


Аймгийн Засаг даргын 2020 оны
..01... дугаар сарын 06 өдрийн А/06...
дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



Зардлын тооцоо

Байгууллагын нэр	Зардлын нэр төрөл			Дүн
	Бичиг хэргийн зардал	Шатахууны зардал	Хоолны зардал	
Цагдаагийн газар	150000	2050200	4400000	6600200
Дүн	150000	2050200	4400000	6600200

Аймгийн Засаг даргын 2020 оны
...01... дугаар сарын...06...өдрийн...06...
дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



Зардлын тооцоо

Байгууллагын нэр	Зардлын нэр төрөл			Дүн
	Бичиг хэргийн зардал	Шатахууны зардал	Хоолны зардал	
Онцгой байдлын газар	150000	306000	1080000	1536000
Дүн	150000	306000	1080000	1536000